

## ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАСГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2024 оны 06 дугаар сарын 10

Багануур дүүрэг

### Дотоод хяналт шалгалтын талаар

Дотоодын хяналт шалгалтаар тахир дутуугийн тэтгэврээс өндөр насны тэтгэвэрт шилжсэн, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь өөрчлөгдсөн, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо өөрчлөгдсөн, нөхөн даатгалын жил болон шимтгэл төлж ажилласан жил, цалин өөрчилсөн хуучин тэтгэвэртэй 75, шинээр тогтоолгосон 235, шилжиж ирсэн 2, нийт 312 тэтгэвэр авагчийн хувийн хэрэг материалын үндэслэл, тооцооллыг шалгалаа.

Шалгалтаар 111 тэтгэврийн материалын зөрчлийг илрүүлэн, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна. Түгээмэл гарсан зөрчлүүд нь зарим саруудын цалин зөрүүтэй бичих, цалингийн орон хаях, архивын лавлагаа, мэдээллийн бааз, нийгмийн даатгалын дэвтрүүд дээрх цалингууд зөрөх, төрсний бүртгэлийн лавлагаа дутуу, нийгмийн даатгалын дэвтэрт цалинг баталгаажуулаагүй мөн 5-н жилийн цалингийн тодорхойлолтыг хяналтаар баталгаажуулаагүй, хөдөлмөрийн дэвтэр болон иргэний үнэмлэхний овог ондоо байх, шимтгэл төлөлтийн архивын лавлагаа дутуу, байгууллагын нэр өөрчилсөн лавлагаа дутуу, ээлжийн амралтын олговрыг харгалзах сард тайлагнаагүй, Засгийн газрын тогтоолоор нэмэгдсэн тэтгэврийн нэмэгдлийг хувийн хэрэгт тэмдэглээгүй, ажилласан жил зөрүүтэй оруулах зэрэг зөрчлүүд гарсныг тухай бүр засуулж, гарч байгаа алдааг дахин гаргахгүй байх, бусад төрлийн нийтлэг гардаг алдаа гарахаас сэргийлэх талаар тэтгэврийн байцаагчид зөвлөгөө өгч ажиллав.

Тайлант хугацаанд дараахь тэтгэврийг шийдвэрлэсэн байна. Үүнд:

№	Тэтгэврийн төлөв	Тэтгэврийн төрөл	Тоо хэмжээ
1	Нийт 312 тэтгэвэр - Үүнээс:	Өндөр насны тэтгэвэр	267
		Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	31
		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	14
2	Нийт 312 тэтгэвэр - Үүнээс:	Шинэ	235
		Хуучин	75
		Шилжиж ирсэн	2
3	Нийт 312 тэтгэвэр - Үүнээс:	Эр	159
		Эм	153
<b>Дүн</b>			<b>312</b>

Шинэ системээр 2024 оны 3 дугаар сарын тэтгэвэр олголтоос эхлэн файл бэлтгэн банкуудад хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Гэвч 2024 оны 6 дугаар сарын бэлтгэсэн файлаар 32 тэтгэвэр авагчид тус бүр 100000 төгрөгийн нэмэгдэл илүү явсан байгааг илрүүлэн тайлант хугацаанд 8 хүнээс уг илүү олгосон 100000 төгрөгийг барагдуулсан байна.

Улсын байцаагчийн актаар тогтоогдсон 12 тэтгэвэр авагчтай холбоотой төлбөрийн оны эхний үлдэгдэл 102270,1 мянган төгрөгийн төлбөрөөс тайлант хугацаанд 1169,5 мянган төгрөгийг барагдуулаад байна.

Хуурамч бичиг баримтаар тэтгэвэр тогтоолгосон 20 тэтгэвэр авагчид 432,593.95 мянган төгрөгийг тэтгэврийн даатгалын санд буцаан төлүүлэхээр тогтоосон улсын байцаагчийн актын оны эхний үлдэгдэл 409822,9 мянган төгрөг байна.

Тайлант хугацаанд нэг тэтгэвэр авагчид илүү олгосон 1413,2 мянган төгрөгийг улсын байцаагчийн акт тогтоож төлүүлсэн.

**Ажилгүйдлийн тэтгэмж** авахаар өргөдөл хүсэлт гаргасан 115 даатгуулагчдын хувийн хэрэг материалын тэтгэмжийн бодолт, баримт материалын бүрдэлт, хуулийн хугацаа зэргийг шалгасан.

**Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны тэтгэмж:**

Тайлант хугацаанд 75 байгууллагын 1819 даатгуулагч, сайн дурын 199 даатгуулагчдын эмнэлгийн хуудсыг зохих журмын дагуу хянаж, шалгав. Үүнд:

			<i>Хүснэгт №10</i>
№	Байгууллага	Тэтгэмжийн төрөл	Тоо хэмжээ
1	Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч – 103	ЖАТ	39
		ХЧТА	64
		Эр	23
		Эм	80
2	75 ажил олгогч байгууллагын тэтгэмж авсан даатгуулагч - 1109	ЖАТ	167
		ХЧТА	940
		ҮОМШӨ ХЧТА	2
		Эр	280
		Эм	660
<b>Дүн</b>			<b>1212</b>

Нэг даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн актын төлбөр 1089606 төгрөг барагдаагүй үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд Цахим хяналтын программын “Тайлан” цэсэнд зөрчилтэй байх магадлалтай 10 төрлийн 252 мэдээлэл бүртгэгдсэнийг шалгав. Эдгээрээс зонхилон гарсан зөрчлүүд нь:

1. Шимтгэлийн программ:

- Аж ахуйн нэгж байгууллагууд 22, 06, 17, 40 кодоор тайлагнах даатгуулагчийг андууран 01 кодоор тайлагнаснаас болоод тухайн сарын шимтгэлийн тайланг устгаж засах,
- Аж ахуйн нэгж байгууллагууд ажилтнаа орхиж тайлагнаснаас шимтгэлийн тайланг засварлах,
- Нэг байгууллагаас гарч нөгөө байгууллагад ажилд орж байгаа даатгуулагчдад 1 сард 2 байгууллага дээр 01 кодтой цалин давхардах,
- Хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхчүүддээ салбарын цалингийн доод хэмжээгээр тэтгэмж олгодгоос үүдэн 06 кодтой даатгуулагчид ХХДоХэмжээгээр шимтгэл төлөөгүй гэсэн зөрчил,
- Улсын байцаагчийн актаар хүүхдээ асарч байсан хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэх,
- Шүүхийн шийдвэрийн дагуу цалин нөхөж шивэх зэрэг шалтгаанаар шимтгэлийн тайлан засаж залруулга хийдэг болно.

2. Хөдөлмөрийн чадвар түр алдсны, жирэмсний болон амаржсны тэтгэмж:

- Сайн дурын даатгалын шинэ программтай холбоотойгоор СДД төлж байгаа даатгуулагчдын цалин нэгдсэн сүлжээн дээр татагдахгүй байх, зөрүүтэй татагдах,
  - Аж ахуйн нэгж байгууллагын ажилчдын ээлжийн амралтын цалинг хуваан тэтгэмж бодлогоос үүдэн нэгдсэн сүлжээний цалинтай тэтгэмж бодсон цалин таарахгүй байх.
3. Ажилгүйдлийн тэтгэмж:
- Ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа иргэд тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орох тохиолдол их байдаг бөгөөд энэ тухайгаа харъяа нийгмийн даатгалын газар, тэтгэмжийн байцаагчид мэдэгддэггүй бөгөөд ажилд орсныг нь цахим хяналтын программаас мэдэх тохиолдол их байна. Цалин, тэтгэмж давхардсан даатгуулагчидтай тухай бүрт нь холбоо барьж зөрүүг тооцон ажилгүйдлийн санг хохиролгүй болгон ажиллаж байна.
4. Тэтгэвэр:
- Даатгуулагчдын ээлжийн амралтын хязгаарлагдаагүй цалинг хувааснаар нэгдсэн сүлжээний цалинтай таарахгүй байх.
  - Шимтгэлийн тайлан ирээгүй байхад дэвтрийн бичилтээр тэтгэвэр тогтоолт хийснээр гарсан зөрүү.

**Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэсэн ажлын талаар**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитын удирдамж”-ийн дагуу 2023 оны шилэн дансны мэдээллийг шалгах ажлыг 2024.01.02-2024.01.04-ний хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Шилэн дансны цахимд хуудсанд Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл оруулсныг шалгахад хугацаа хоцроож мэдээлсэн 6, хугацаандаа байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

Тухай бүр, сар, улирал, хагас жил, бүтэн жилээр холбогдох мэдээллийг оруулсан эсэхийг шалгахад батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тайланг шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаа хоцроож оруулсан байна.

Шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийг оруулсныг харахад хугацаа хоцроож мэдээлсэн 7, хугацаандаа байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

Тухай бүр, сар, улирал, хагас жил, бүтэн жилээр холбогдох мэдээллийг оруулсан эсэхийг шалгахад байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг биелүүлсэн эсэхийг шалгахад ЦЭБэ Консалтинг аудит ХХК нь 2022 оныг хамруулан тус хэлтэст шалгалт явуулсан байна. Аудитаар өгсөн зөвлөмжөөр шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан байна. 2022 оны 04-р сарын Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Хөрөнгийн зардал, хөрөнгө

оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт гэсэн 4 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байх бөгөөд шилэн дансны цахим хуудсанд сар, улирал, тухай бүрт оруулах мэдээллүүдийг хугацаанд нь үнэн зөв тогтмол оруулж байгаа тайлбарыг аудитын өгсөн зөвлөмжийн биелэлтээр 2023.05.25-нд хүргүүлжээ.

**Салбарын хяналтын Улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 дугаартай “Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамж**

Уг удирдамжийн дагуу тус нийгмийн даатгалын газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Б.Хишигжаргал, Г.Бямбажаргал, О.Пүрэвжав, ахлахаар Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Г.Ганбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2024 оны 04 дүгээр сарын 08-наас 12-ны өдрүүдэд ирж ажиллалаа.

Шалгалтаар Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбогдох санхүүгийн баримт материал, тус сангийн цахимжилт, тус сангаас санхүүжилт авсан аж ахуйн нэгж байгууллага, иргэд мөн өмнөх онуудад тус санд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн, акт, албан шаардлагын биелэлт, үр дүнг шалгасан.

Тус сангаас 2021-2023 онд тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авч буй нийт тэтгэвэр авагчдын тэтгэвэр тогтоолтын үндэслэлийг хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт материалд тулгуурлан шалгах, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж болон хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөрийн бодолт олголтыг үндсэн баримттай тулган шалгах, 2021-2023 онд үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл төлөлтийг шалгах зэргээр шалгалтад хамрагдлаа.

**Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны талаар**

2024 онд шинээр мөрдөгдөж буй эрх зүйн баримтуудын хэрэгжилтийг ханган ажиллав.

Үүнд:

- Засгийн газрын 2023 оны 12 сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн дүрэм шинэчлэгдэн батлагдсан.
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ний өдрийн А/38 дугаар тушаалаар дүүргийн Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдэн батлагдсан.
- Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/441, А/192 дугаар хамтарсан тушаалаар “Даатгуулагч хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт шинэчлэн батлагдсан.

Дээрх эрх зүйн баримтуудыг үндэслэн Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн хурал долоо хоногийн Пүрэв гарагийн 15:00 цагт, Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвд 80-100% ирцтэй хуралдаж, өвчтөний бичиг баримтад үндэслэн нийт 18 удаа хуралдаж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, хэмжээг 45 иргэнд шинээр тогтоож, 20 иргэний ХЧА-ын хувь хэмжээг цуцалж, 182 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж шийдвэрлэсэн нийт 886 иргэн хөдөлмөрийн чадвар алдалтын

хувь хугацаа, хэмжээг тогтоолгосон иргэн байна. Энэ нь дүүргийн нийт хүн ам /29342/-ын 3 хувийг эзэлж байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтыг өвчний шалтгаанаар ангилбал сэтгэцийн эмгэг, дотрын өвчин, мэдрэлийн эмгэг, сонсгол тэнцвэрийн эрхтний эмгэг, нүд, гэмтлийн эмгэгүүд эхний 6 байр буюу нийт хөдөлмөрийн чадвар алдалтын 90 хувийг эзэлж байгаа ба хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн 79 хувь нь 31-59 насны хөдөлмөрийн насны иргэд байна.

Мэдээллийн сангийн зөрүүний хяналтыг улирал болгон тулган зөрүү гарахаас урьдчилан сэргийлж улирал тутам нийгмийн даатгал, нийгмийн халамж, зөвлөлийн мэдээлэл, хорих ангийн тэтгэвэр авагчдын мэдээллийг тулган хянаж ажилладаг. Хагас жилийн хяналтаар 910 иргэний мэдээлэлд тулгалт хийж хянахад нас барсан 1, шилжсэн 2, шимтгэл төлсөн хугацааг үндэслэн 3 хүний мэдээлэлд хөдөлгөөн хийж зөрүүг арилгалаа.

Хөдөлмөрийн чадвар алдалтыг ердийн өвчнөөс гадна үйлдвэрлэлийн ослоор тогтоолгосон 24 хүн байна. Нийт цуцалсан 20, шилжсэн 2, шилжиж ирсэн 5, нас барсан 3 иргэн. Одоо идэвхтэй тэтгэвэр авч байгаа 886 иргэн байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоолгосон 566 иргэн нийгмийн даатгалын сангаас, 320 иргэн нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байна. Хөдөлмөрийн чадвараа 50-69%-аар алдсан 456/51%, 70-100% алдсан 430/49% иргэн байна.

Шинэ хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалтыг хэрэгжүүлэн ажиллахад өмнөх хувь буурсан 16, хувь өссөн 25 иргэн байна. Шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг тогтоолгож буй иргэний оношийг магадлах, биеийн байдлыг үнэлэх, мэдээлэл солилцох, эмчлэн эрүүлжих зөвлөгөө өгөх, цаашид зөв чиглүүлэх зэрэг асуудлаар хуралд иргэнийг өөрийг нь байлгах шаардлагатай тул иргэнг биеэр хуралд оролцуулан шийдвэрлэж байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой дүрэм, журмыг зөрчих, авлига, ашиг сонирхол, ёс зүйн аливаа алдаа дутагдал гарахаас урьдчилан сэргийлж ажилладаг.

- ✓ ЭММЗ-н хурал эхлэхээс өмнө хурлаар орох иргэдийн нэрсийн жагсаалтыг гишүүдэд танилцуулж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдүүлгийг амаар авч ашиг сонирхол үүссэн бол маягт бөглөн хурлын даргад танилцуулан шийдвэрлэн ажиллаж хэвшсэн.
- ✓ ЭММЗ-ын хурлын үйл явцыг дүрс бичлэгт буулган, цахим хэлбэрээр тухайн сардаа хадгалан ажилладаг.

#### Эмнэлгийн хуудасны хяналт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 сарын 07-ны өдрийн А/177, А/433 хамтарсан тушаалаар Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журмыг баталсан. Уг тушаалыг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн, арга зүйн зөвлөгөө өгч, уялдаа холбоотой, хяналттай ажилладаг.

Энэ оны 06 сарын 10-ны өдрийн байдлаар цахимаар 1520 эмнэлгийн хуудасны хүсэлт авч шийдвэрлэн ажилласан байна. Үүнд:

№	Цахим эмнэлгийн хуудасны төлөв	ХЧТА	ЖА	НИЙТ
1.	Шийдэгдсэн	851	172	<b>1023</b>
2.	Цуцлагдсан	319	72	<b>391</b>
3.	Боловсруулж байгаа	92	14	<b>106</b>
	<b>Нийт</b>	<b>1262</b>	<b>258</b>	<b>1520</b>

Нийт 1520 эмнэлгийн хуудсыг хянан баталгаажуулсан бөгөөд салбарын шинэ программд иргэний мэдээлэл зөрүүтэй болон дутуу татагдсан хүсэлтийг цуцалж дахин хүсэлт илгээх шаардлага гарч байсан нь ажлын ачааллыг нэмсэн.

### **Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн ажил**

Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ний өдрийн 362 дугаар тогтоолоор Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрмийг баталсан.

Даатгуулагч, хүн, ажил олгогч, нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрүү, маргааныг хянан шийдвэрлэх Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн зохион байгуулалт үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах зорилготой тус зөвлөлийн дүрмийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр батлагдсан дүрмийн холбогдох заалтын хүрээнд Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн даргаар тус газрын дарга ажиллаж, салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай зөвшилцөн томилсон.

Салбар зөвлөлд нийгмийн даатгалын байгууллагаас 3, нутгийн захиргааны байгууллагын нийгмийн бодлого, хөгжлийн асуудал хариуцсан нэгжээс 2, ажил олгогч, даатгуулагчийн төлөөллөөс тус бүр 1 хүнийг томилохоор дүрэмд тусгагдсаны дагуу дүүрэг орон нутгийн холбогдох байгууллагуудад Монгол улсын Засгийн газрын 2023 оны 362 дугаар тогтоолоор баталсан “Дүрэм батлах тухай” тогтоол, түүний хавсралт дүрмийг хүргүүлэн саналуудыг авч холбогдох дээд шатны байгууллагад уламжлан бүрэлдэхүүнийг зөвшилцөн томилсон. Салбар зөвлөл дэх нэг албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн, шинээр албан хаагч томилогдсон, албан хаагчдын албан тушаал өөрчлөгдсөнтэй холбоотой зөвлөлийн бүрэлдэхүүнд тайлант хугацаанд нэг удаа өөрчлөлт орсон.

Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрмийг удирдлага болгон үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж эхний хагас жилийн байдлаар салбар зөвлөл нэг удаа хуралдаж хурлаар 4 иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн.

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТ,ДОТООД АУДИТЫН ТАСГИЙН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
БАЙЦААГЧ Ц.СОЛОНГО